



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

XII сар

Судалгааг захиалагч:

Улсын Их Хурлын Тамгын газар

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Энх-Амгалан

Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын
эрхлэгч

С.Нарантунгалаг

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан



АГУУЛГА

I. УДИРТГАЛ	4
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	5
2.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох	5
2.1.1 Улсын Их Хурлын Тамгын газарт үүсэх зардлын тооцоо	10
2.1.1.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох	10
2.1.1.2 Гарах зардлыг урьдчилан тооцох	15
2.1.1.3 Үр дүнг тооцох	16
2.1.1.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	17
2.1.2 Засгийн газарт үүсэх зардлын тооцоо	18
2.1.2.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох	18
2.1.2.3 Үр дүнг тооцох	21
2.1.2.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	22
2.1.3 Хууль зүйн үндэсний хүрээлэнд үүсэх зардлын тооцоо	22
2.1.3.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох	22
2.1.3.2 Гарах зардлыг урьдчилан тооцох	24
2.1.3.3 Үр дүнг тооцох	25
2.1.3.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	26
2.1.4 Ерөнхийлөгчийн Тамгын газарт үүсэх зардлын тооцоо	26
2.1.4.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох	26
2.1.4.2 Гарах зардлыг урьдчилан тооцох	27
III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО	27
IV. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	29
V. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	30
ЭХ СУРВАЛЖ	32



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
МУИХтХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
ХБХЭтХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
ХТтХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ХТтХНӨОтХ	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЭЗМНС	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан



ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

I. УДИРТГАЛ


Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд “...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.”, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж, Монгол Улсын хүний эрхийн олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээ аваагүй байгаа бол энэхүү Пактад оролцогч улс бүр үндсэн хуулийнхаа журам болон энэ Пактын заалтад нийцүүлэн түүнд хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээг авах үүрэгтэй.” гэж тус тус заасан нь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

УИХ-ын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний 1 дэх зорилгод хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлнэ хэмээн заасан бөгөөд хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, тайлагнах бүх үе шатанд хүн төвт үзэл санаанд суурилсан, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалсан байх зарчим, шаардлагыг тэргүүн эрэмбэд тавих зорилт дэвшүүлсэн. Монгол Улсын ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.14-т “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээ авна” гэж тусгажээ. Эдгээр бодлогын баримт бичгийн зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс суурь нь хууль, УИХ-ын бусад шийдвэрийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй ХТТХ-ийг боловсронгуй болгох явдал хэмээн үзэж, тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төсөл боловсруулсан байна.

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /цаашид “ХТТХНӨТХ” гэх/ -ийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцов.

Судалгааны зорилго. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд,

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.



төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, зардлыг бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго чиглэгдэнэ.

Төрийн байгууллагын зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээнд, хуулийн этгээдийн зардлыг хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардалд, иргэнд үүсэх зардлыг хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацаанд тус тус үндэслэн тооцохоор Аргачлалд заасан. Иймд ХТтХНӨОтХ батлагдсанаар үүсэх зардлын тооцоог хийхдээ дараах нийтлэг зарчмыг баримтлав. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохдоо уг төслийг “нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” хэлбэрээр боловсруулсан тул шинээр үүссэн буюу өмнө нь гүйцэтгэж байгаагүй үүрэг болон өмнө нь гүйцэтгэж байсан боловч тухайн үүргийг хуулийн төслөөр өргөжүүлсэн бол тухайн хүрээнд хязгаарлан зардал тээгч этгээдийн зардлыг тооцсон болно. Өөрөөр хэлбэл, хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж байгаа үүрэг эсхүл өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийн өргөжүүлсэн хэсэгт зардал тооцно.

Судалгааны үр дүнд үндэслэн, тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэв.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
3. Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

“Гүйцэтгэх үүрэг” гэдэгт хуулийн төслөөр төрийн байгууллагад даалгасан ажил, үйлчилгээг ойлгох ба Аргачлалын 4.4.6-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулаагүй болно.

Төрийн байгууллагын үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- Тухайн хууль тогтоомж /зохицуулалт/-д хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
- Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
- Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

2.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Судалгааны энэхүү хэсэгт хуулийн төслийн зохицуулалтыг уншиж судлах замаар тодорхой үүрэг хүлээж буй байгууллагыг тодорхойлж, тухайн байгууллага ямар чиг үүрэг

буюу ажил үйлчилгээ шинээр гүйцэтгэх эсвэл өнөөгийн гүйцэтгэж байгаа чиг үүрэг, ажил үйлчилгээ нь уг хуулийн төслийн дагуу өргөжиж байгаа эсэхийг тогтоох юм.

ХТТХНӨТХ-ийн төсөл нь хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог хангах болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах гэсэн гурван хүрээнд боловсруулсан дараах агуулга бүхий 6 зүйлтэй. Үүнд:

- Хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, саналыг тусгах боломж бүхий нэгдсэн цахим систем ажиллуулах;
- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохдоо төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох;
- Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт агуулсан хуулийн төсөлд холбогдох төрийн байгууллагаас санал авах;
- Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төсөл боловсруулахад тавигдах шалгуур, шаардлагыг тодорхой болгох;
- УИХ, ЗГ-аас ямар хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхийг тодорхой болгох;
- Хууль тогтоомжийн батлагдсан эх хувь, хууль тогтоомжийн үзэл баримтлал, хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийн түүх, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д оруулах.

Дээрх агуулга бүхий хуулийн төслөөс үнэлгээ хийх зохицуулалтыг сонгохдоо хэрэгжүүлэх чиг үүрэг, хэмжих боломжтой ажил, үйлчилгээг тусгасан зохицуулалтыг сонголоо. Үүнд, хуулийн төсөл батлагдсанаар тодорхой байгууллага, субъектэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсхүл тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж бий болгох шаардлагатай эсэх зэрэг зардал үүсгэж болохуйц зохицуулалтууд хамаарна.

ХТТХНӨТХ-ийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг /ажил, үйлчилгээ/-т хамаарах дараах зохицуулалт байна. Үүнд:

Хүснэгт 1. Стандарт үйл ажиллагааг тогтоох нь

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ
Хуулийн төслөөр ХТТХ-д нэмэлт оруулсан хэсэг		
18.3.Улсын Их Хурлын гишүүн санаачлан боловсруулж буй хууль тогтоомжийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газрын төсвийн хяналт шинжилгээ хариуцсан нэгж энэ хуулийн 18.1-д заасан зардлын тооцоог хийнэ.	УИХТГ /Төсвийн хяналт, шинжилгээ хариуцсан нэгж/	Хууль тогтоомжийн төсөлд зардлын тооцоо хийх
41.4.Улсын Их Хурлын Тамгын газрын парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн шинжээч энэ хуулийн 17.2.4-т заасан хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд ажлын 5 өдрийн дотор дүгнэлт гаргана.	УИХТГ /Парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгж/	Хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах
44.3.Холбогдох төрийн байгууллага нь хүний хувийн мэдээлэл, төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй иргэд, олон	Холбодох төрийн байгууллага /УИХТГ/	Хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй танилцах нөхцөлийг бүрдүүлэх

нийт чөлөөтэй танилцах нөхцөлийг бүрдүүлнэ.		
45.5.Хууль тогтоомжийн цахим сан нь хөгжлийн бэрхшээлтэй хүн онцлог хэрэгцээндээ тохирсон хэлбэрээр ашиглах боломжтой байна.	ХЗҮХ	ЭЗМНС-д хөгжүүлэлт хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохируулах
51.6.Энэ хуулийн 49.1, 49.2-т заасан этгээд хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.	УИХ, ЗГ, ХЗҮХ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах
Хуулийн төслөөр ХТтХ-д өөрчлөлт оруулсан хэсэг		
38.7.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.	Хууль санаачлагч /Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн Газар/, ХЗҮХ	Хуулийн төслийн саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах

Хуулийн төслийн зохицуулалтаас үзвэл, хууль санаачлах эрх эдлэх Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн Газар болон Улсын Их Хурлын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх үүрэг бүхий УИХТГ, Засгийн газрын ажлын алба болох ЗГХЭГ мөн ХЗДХЯ-ны харьяа хууль зүйн судалгаа, сургалт, мэдээллийн байгууллага болох ХЗҮХ-д үүрэг үүсчээ.

Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгох хүрээнд хуулийн төсөлд тодорхойгүй, ойлгомжгүй байдлаар тусгасан дараах зохицуулалтад дүн шинжилгээ хийж, төсөлд заасан чиг үүргийг гүйцэтгэх төрийн байгууллагыг тухайлан тодорхойлов. Үүнд:

1. Хуулийн төслийн 44.3 дахь хэсэгт заасан “Холбогдох төрийн байгууллага” гэсэн нь чиг үүргийг гүйцэтгэх төрийн байгууллагыг тодорхойгүй болгосон байх тул МУИХтХ-ийн 46.5.17-д үндэслэж, төслийн 44.3 дахь хэсэг нь УИХТГ-ын чиг үүрэгт хамаарна гэж үзэв.
2. Хуулийн төслийн 51.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 49.1, 49.2-т заасан этгээд” гэсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх эсхүл үнэлгээг хийх байгууллагад үүрэг үүсгэсэн нь ойлгомжгүй байна. Иймд ХТтХ-ийн 49.8 дахь хэсгийг үндэслэн, МУИХтХ-д заасны дагуу УИХ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах, хуульд заасан бусад ажлыг эрхлэх үүрэг бүхий УИХТГ болон МУЗГтХ-д заасны дагуу ЗГ-ын ажлын алба болох ЗГХЭГ хуулийн төслийн 51.6 дахь хэсгийн чиг үүргийг гүйцэтгэнэ гэж тогтоов.

Төрд үүсэх зардлыг тодорхойлохын тулд байгууллага тус бүр хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4/18 дугаар зүйлийн 18.3, 13/41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, 14/44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг болон 16/51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгээр УИХТГ-ын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой стандарт үйл ажиллагааг тодорхойлжээ.

Хүснэгт.2 УИХТГ-ын стандарт үйл ажиллагаа

Хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа
УИХТГ /Төсвийн хяналт, шинжилгээ хариуцсан нэгж/	18.3 дахь хэсэг: Хууль тогтоомжийн төсөлд зардлын тооцоо хийх	УИХ-ын гишүүний санаачлан боловсруулсан хуулийн төслийг хүлээн авах
		Хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, холбогдох бусад судалгааны тайлантай танилцах
		Судалгаа/зардлын тооцоо/ хийх
		Судалгааны тайлан боловсруулах
УИХТГ /Парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн Хүний эрхийн шинжээч/	41.4 дэх хэсэг: Хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах	Хуулийн төслийг хүлээн авах
		Хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, холбогдох бусад судалгааны тайлантай танилцах
		Аргачлалын дагуу шалгах
		Дүгнэлт гаргах
УИХТГ	44.3 дахь хэсэг: Хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт чөлөөтэй танилцах нөхцөлийг бүрдүүлэх	Хуулийн хувийн хэргийг цахимаар нээлттэй байршуулах
		Хуулийн хувийн хэргийг цаасан хэлбэрээр нээлттэй байршуулах
УИХТГ	51.6 дахь хэсэг: Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах	Хэрэгжилтийг үнэлгээний үр дагаврын тайланг хүлээн авах
		Хэрэгжилтийг үнэлгээний үр дагаврын тайланг цахим хэлбэрт оруулах
		Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч байршуулах

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн **16/51** дүгээр зүйлийн **51.6** дахь хэсгээр ЗГХЭГ-ын гүйцэтгэх үүрэгтэй холбоотой стандарт үйл ажиллагааг тодорхойлжээ.

Хүснэгт.3 ЗГХЭГ-ын стандарт үйл ажиллагаа

Хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа
ЗГХЭГ	51.6 дахь хэсэг: Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах	Хэрэгжилтийн үнэлгээний үр дагаврын тайланг хүлээн авах
		Хэрэгжилтийн үнэлгээний үр дагаврын тайланг цахим хэлбэрт оруулах
		Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч байршуулах

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн **15/45** дугаар зүйлийн **45.5**, **16/51** дүгээр зүйлийн **51.6**, **5/38** дугаар зүйлийн **38.7** дахь хэсгээр ХЗҮХ-ийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой стандарт үйл ажиллагааг тодорхойлжээ.

Хүснэгт.4 ХЗҮХ-ийн стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл Ажиллагаа
---------------------------------	---	------------------------

ХЗҮХ	45.5 дахь хэсэг: ЭЗМНС-д хөгжүүлэлт хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохируулах	ЭЗМНС-д бичвэрийг дуу авиад шилжүүлэх хүрээнд системийн хөгжүүлэлтийн ажил хийх
		ЭЗМНС-д нэвтрүүлэх, хэрэглэх
	51.6 дахь хэсэг: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг байршуулах боломжтой хэсгийг ЭЗМНС-д нэмэх	Системийг хөгжүүлэх
	38.7 дахь хэсэг: Хуулийн төслийн саналын товъёгийг байршуулах хэсгийг ЭЗМНС-д нэмэх	Системийн шинэчлэлтийг нэвтрүүлэх
		Хуулийн төслийн саналын товъёгийг хүлээн авах
		ЭЗМНС-д оруулах, мэдээлэл байршуулах

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 5/38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгээр хууль санаачлагчийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой стандарт үйл ажиллагааг тодорхойлжээ.

ХТТХ-ийн 38.7 дахь хэсгээр “Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна.” гэснийг **хуулийн төсөлд өөрчлөн найруулж** төслийн 3 дугаар зүйлийн 5/38.7 дахь хэсгээр “Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна” гэсэн байна.

Өөрөөр хэлбэл, хууль санаачлагчийн гүйцэтгэдэг үүргийг хуулийн төслөөр өргөжүүлэн “**ЭЗМНС-д саналын товъёгийг байршуулах**” үүрэг үүсгэжээ. Иймд Аргачлалд заасны дагуу өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийн өргөжүүлсэн хэсэгт буюу “Хууль санаачлагч саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах” үүрэгт зардал тооцно. Хууль санаачлагч гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно” гэж заасны дагуу холбогдох зардлыг тооцсон.

Мөн төслийн зохицуулалтаар “... Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.” гэж заасны дагуу ЭЗМНС-д гарах зардлыг хүснэгт 4-т тусгасан ХЗҮХ-ийн стандарт үйл ажиллагааны дагуу тооцсон болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч

МУИХТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно.”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 17.1-д “Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгчийн Тамгын газар мөн.” гэж тус тус заасны дагуу хуулийн төсөлд заасан уг чиг үүргийг Ерөнхийлөгчийн Тамгын газар гүйцэтгэж байна.

Улсын Их Хурлын гишүүн

МУИХТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтад “Улсын Их Хурлын үйл

ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах ба бусад хуулийн төслийг өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэх, батлахдаа дагалдах хэлбэрээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно;”, 36.2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно.”, 46.5.1 дэх заалтад “Улсын Их Хурал, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсэг, гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;” гэж тус тус заасны дагуу хуулийн төслийн уг чиг үүргийг УИХТГ гүйцэтгэж байна.

Засгийн газар

МУИХТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтад “Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах” гэж, 36.2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно.” гэж тус тус заасны дагуу Засгийн газрын ажлын алба болох ЗГХЭГ хуулийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах үүрэгтэй гэж үзлээ.

Хүснэгт.5 Хууль санаачлагчийн стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл Ажиллагаа
Ерөнхийлөгч-Ерөнхийлөгчийн Тамгын газар	Хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг байршуулах	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтрэх
		ЭЗМНС-д мэдээлэл байршуулах
УИХ-УИХТГ	Хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг байршуулах	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтрэх
		ЭЗМНС-д мэдээлэл байршуулах
ЗГ-ЗГХЭГ		Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтрэх
		ЭЗМНС-д мэдээлэл байршуулах

Төрийн байгууллагын стандарт үйл ажиллагааг тогтоосон тул байгууллага тус бүрээр зардлын тооцоог гүйцэтгэнэ.

2.1.1 Улсын Их Хурлын Тамгын газарт үүсэх зардлын тооцоо

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистик мэдээллийг тооцсон болно.

2.1.1.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4/18 дугаар зүйлийн 18.3, 13/41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, 14/44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг болон 16/51 дүгээр зүйлийн 51.6 болон 3 дугаар зүйлийн 5/38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгээр УИХТГ-д холбогдох дараах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг чиг үүрэг тус бүрээр тодорхойлъя.

Чиг үүрэг 1. УИХ-ын гишүүний санаачлан боловсруулсан хуулийн төсөлд зардлын тооцоо хийх

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 буюу 18.3 дахь хэсэгт УИХ-ын гишүүний санаачлан боловсруулсан хуулийн төсөлд УИХТГ-ын төсвийн хяналт шинжилгээ хариуцсан нэгж (Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс) зардлын тооцоо хийхээр тусгажээ.

МУИХТХ /шинэчилсэн найруулга/-ийн 46 дугаар зүйлийн 46.5-д “Тамгын газар дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ”, 46.5.6.-д “Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх”, 46.5.14-д “Улсын Их Хурлаас хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх явцад шаардлагатай судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх” гэж тус тус заасны дагуу УИХТГ УИХ-ын гишүүний санаачилсан хуулийн төсөлд зардлын тооцоо гүйцэтгэх үүрэгтэй байна. Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4/18.3-т заасан “Зардлын тооцоо” гүйцэтгэх үүрэг нь тухайн байгууллагад **шинээр үүрэг үүсгээгүй зохицуулалт байна.**

Өөрөөр хэлбэл, МУИХТХ-аар хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын зардлын тооцоог УИХТГ-т үүрэг болгосныг тус хуулийн төсөлд “УИХТГ-ын төсвийн хяналт, шинжилгээ хариуцсан нэгж” гэж нарийвчлан заасан нь тус байгууллагын хүний нөөцийн хэрэгцээ нэмэгдэх, зардал өсөх үндэслэл болохгүй. Иймээс хуулийн төсөлд заасан тухайн үүргийг бусад хуулиар зохицуулсан төдийгүй практикт хэрэгжиж, хэвшсэн ажил үүрэг гэсэн үндэслэлээр нэмж зардал үүсэхгүй гэж үзлээ.

Хүснэгт 6. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХТГ-ын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс	УИХ-ын гишүүний санаачлан боловсруулсан хуулийн төслийг хүлээн авах	-	-	-
	Хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, холбогдох бусад судалгааны тайлантай танилцах	-	-	-
	Судалгаа хийх/зардлын тооцоо/	-	-	-
	Судалгааны тайлан боловсруулах	-	-	-
Нийт				0

Чиг үүрэг 2. УИХТГ-ын Парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн шинжээч хууль тогтоомжийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах

Хууль тогтоомжийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах чиг үүргийг УИХТГ-ын парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн шинжээч тогтмол буюу тасралтгүй

гүйцэтгэх үүрэгтэй гэж үзлээ. Төхиолдлын тоог тогтоохдоо ЭЗМНС www.legalinfo.mn болон www.d.parliament.mn цахим хуудсуудад 2024.01.01-2024.12.15-ны өдрийн хооронд санал авахаар байршуулсан төслийн тоог үндэслэж баримжаа болгов.

Хүснэгт 7. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Төхиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХТГ-ын парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн шинжээч	Хуулийн төсөл хүлээн авах	10	50	500
	Хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, холбогдох бусад судалгааны тайлантай танилцах	60	50	3000
	Аргачлалын дагуу шалгах	480	50	24000
	Дүгнэлт гаргах	60	50	3000
Нийт				30500

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 х 8) 1600 ажлын цаг буюу (1600 х 60) 96.000 минут ажиллана. Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тухайн хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 8. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
УИХТГ-ын парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн шинжээч	Хуулийн төсөл хүлээн авах	500	96000	0.05
	Хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, холбогдох бусад судалгааны тайлантай танилцах	3000	96000	0.03
	Аргачлалын дагуу шалгах	24000	96000	0.25
	Дүгнэлт гаргах	3000	96000	0.03
Нийт				0.36

УИХТГ-ын Парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн шинжээч хууль тогтоомжийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт өгөх үүргийг хэрэгжүүлэхэд нийт 30500 минут зарцуулах ба шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ **0.36** байна.

Чиг үүрэг 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах

Хүснэгт 9. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХТГ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан хүлээн авах	10	30	300
	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг цахим хэлбэрт оруулах	10	30	300
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах	20	30	600
Нийт				1200

Хүснэгт 10. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
УИХТГ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан хүлээн авах	300	96000	0.003
	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг цахим хэлбэрт оруулах	300	96000	0.003
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах	600	96000	0.006
Нийт				0.012

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах үүргийг хэрэгжүүлэхэд нийт 30500 минут зарцуулах ба шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ **0.012** байна.

Чиг үүрэг 4. Хуулийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт танилцах боломжийг бүрдүүлэх

Хуулийн төслийн 14/44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг нь иргэд, олон нийт хуулийн хувийн хэрэгтэй цаасан болон цахим хэлбэрээр танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар үүрэг болгосон зохицуулалт юм. Хуулийн хувийн хэрэгтэй цаасан хэлбэрээр танилцах боломжийг бүрдүүлэхдээ өнөөгийн нөөцөд тулгуурлан шийдвэрлэх буюу МУИХтХ-ийн 46.4-т “Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжид парламентын номын сан байна” гэж заасны дагуу уг номын санг иргэдэд нээлттэй болгох замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Харин хуулийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт цахимаар танилцах боломжийг бүрдүүлэхдээ ЭЗМНС-д хуулийн хувийн хэргийг байршуулах замаар шийдэх бололцоо бий. Хууль тогтоомжийн бүрдүүлбэрийг нэгтгэн цахим санд төвлөрүүлэн байршуулснаар иргэд, олон нийт мэдээллийг нэг дороос хялбар бөгөөд хүртээмжтэй байдлаар олж авах боломжтой болно. Түүнчлэн хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 5/38 дугаар зүйлийн 38.7, 16/51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгээр ЭЗМНС-д хууль тогтоомжтой холбогдох зарим баримт бичгийг байршуулах үүрэг бий болгосон байх тул тус санд хуулийн хувийн хэргийг байршуулах нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцнэ. Холбогдох зардлыг тус тайлангийн ХЗҮХ-нд үүсэх зардлын тооцоо хэсэгт тооцов.

Чиг үүрэг 5. УИХ-ын гишүүний санаачилсан хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах

Хууль тогтоомжийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах чиг үүргийг УИХТГ-ын холбогдох нэгж тогтмол буюу тасралтгүй гүйцэтгэх үүрэгтэй ба тохиолдлын тоог тогтоохдоо ЭЗМНС www.legalinfo.mn болон www.d.parliament.mn цахим хуудсуудад 2024.01.01-2024.12.15-ны өдрийн хооронд санал авахаар байршуулсан төслийн тоог үндэслэж баримжаа болгов.

Хүснэгт 11. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХТГ	ЭЗМНС-д эрх бүхий этгээд нэвтрэх	5	50	250
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт саналын товъёгийг байршуулах	20	50	1000
Нийт				1250

Хүснэгт 12. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
------	---------------	------------------------------	---------------------------------	----------------------------------

УИХТГ	ЭЗМНС-д эрх бүхий этгээд нэвтрэх	250	96000	0.002
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтрэх тохирох хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах	1000	96000	0.1
Нийт				0.12

2.1.1.2 Гаргах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай.

УИХТГ-ын холбогдох албан хаагчийн цалинг Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан *“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*, МУИХ-ын 2019 оны 18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан *“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай”*, МУИХ-ын 2020 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан *“Цалингийн хэмжээг тогтоох тухай итгэлцүүр батлах тухай”* баримт бичиг болон төрийн албан хаагчийн цалинтай холбогдох бусад хууль, дүрэм, журмыг тус тус үндэслэж тооцоолов.

Чиг үүрэг 1 буюу УИХ-ын гишүүний санаачлан боловсруулсан хуулийн төсөлд УИХТГ-ын төсвийн хяналт, шинжилгээ хариуцсан нэгж “зардлын тооцоо”-ны судалгаа гүйцэтгэхэд зардал үүсэхгүй.

Чиг үүрэг 2 буюу хууль тогтоомжийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах үүрэгтэй УИХТГ-ын парламентын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн шинжээчийн /АА-7 зэрэглэл/ үндсэн цалингийн хэмжээ нь 2,171,000 төгрөг байна.² Үүнийг МУИХ-ын 2020 оны 42 дугаар тогтоолын дагуу УИХТГ-ын шинжээч албан тушаалын сарын цалингийн итгэлцүүр болох 1.60 дүнгээр тооцож нэмэгдүүлнэ. Иймд тус албан тушаалын үндсэн цалингийн хэмжээ **3,473,600** төгрөг байна. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар **3,935,600** төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 47,227,200 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь

² Ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

АА-1 2,562,000
АА-2 2,440,000
АА-3 2,374,000
АА-4 2,327,000
АА-5 2,281,000
АА-6 2,236,000
АА-7 2,171,000
АА-8 2,048,000
АА-9 1,933,000
АА-10 1,757,000
АА-11 1,452,000

12.5 хувь буюу сард 491,950 төгрөг буюу жилд 5,903,400 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **53,130,600** төгрөг байна.

Чиг үүрэг 3 буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах мэргэжилтний /АА-8 зэрэглэл/ үндсэн цалингийн хэмжээ нь 2,171,000 төгрөг байна.³ Үүнийг МУИХ-ын 2020 оны 42 дугаар тогтоолын дагуу УИХТГ-ын шинжээч албан тушаалын сарын цалингийн итгэлцүүр болох 1.45 дүнгээр тооцож нэмэгдүүлнэ. Иймд тус албан тушаалын үндсэн цалингийн хэмжээ **3,147,950** төгрөг байна. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар **3,609,950** төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 43,319,400 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 451,243.75 төгрөг буюу жилд 5,414,925 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **48,734,325** төгрөг байна.

Чиг үүрэг 4 буюу хуулийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт танилцах боломжийг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд цаасан болон цахим хувилбар тус бүрт холбогдох саналыг дэвшүүлсэн болно.

Чиг үүрэг 5 буюу хуулийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах мэргэжилтний /АА-8 зэрэглэл/ үндсэн цалингийн хэмжээ нь 2,171,000 төгрөг байна.⁴ Үүнийг МУИХ-ын 2020 оны 42 дугаар тогтоолын дагуу УИХТГ-ын шинжээч албан тушаалын сарын цалингийн итгэлцүүр болох 1.45 дүнгээр тооцож нэмэгдүүлнэ. Иймд тус албан тушаалын үндсэн цалингийн хэмжээ **3,147,950** төгрөг байна. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар **3,609,950** төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 43,319,400 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 451,243.75 төгрөг буюу жилд 5,414,925 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **48,734,325** төгрөг байна.

Уг зардлын хэмжээг дээр тодорхойлсон **хүний нөөцийн хэрэгцээнд** тулгуурлаж тооцвол хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 13. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
УИХТГ	Чиг үүрэг 1= 0	-	-
	Чиг үүрэг 2= 0.36	53,130,600	19,127,016
	Чиг үүрэг 3=0.12	48,734,325	5,848,119
	Чиг үүрэг 4=0	-	-
	Чиг үүрэг 5=0.12	48,734,325	5,848,119
Нийт			30,823,254

2.1.1.3 Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардал гарна.

“Материаллаг зардал” гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

³ Мөн тэнд.

⁴ Мөн тэнд.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 14. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434

Хүснэгт 15. Төрийн байгууллагын нэмэгдэж буй материаллаг зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн материаллаг зардал	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
УИХТГ	Чиг үүрэг 1= 0	-	-
	Чиг үүрэг 2= 0.36	5,395,434	1,942,356
	Чиг үүрэг 3=0.12	5,395,434	647,452
	Чиг үүрэг 4=0	-	-
	Чиг үүрэг 5=0.12	5,395,434	647,452

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 16. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)
УИХТГ	0.6	30,823,254	3,237,260

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд УИХТГ-ын тухайд холбогдох хүний нөөцийн цалингийн зардалд нийт 30,823,254 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 3,237,260 төгрөг, нийт **34,060,514** /Гучин дөрвөн сая жаран мянга таван зуун арван дөрөв/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.1.1.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Аргачлалын дагуу, хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах төсвийн зардлыг бууруулах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар бий эсэхийг шалгана. Үүнд:

Тохиолдлын тоог багасгах боломж бий эсэх

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үзнэ. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13/41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг болон 16/51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгээр УИХТГ-ын хэрэгжүүлэх үүрэг нь тасралтгүй үргэлжлэх, тогтмол шинжтэй үүрэг тул тохиолдлын тоог бууруулах боломжгүй юм.

Өөр хувилбар бий эсэх

Хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх нь улсын төсөвт тодорхой зардал үүсгэхээр байх боловч нийгэмд үзүүлэх эерэг үр нөлөө их байна. Тухайлбал иргэд олон нийтэд хуулийн хэрэгжилтийн үр дагавартай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, мөн хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн этгээд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой. Хуулийн төслийн зохицуулалт нь УИХТГ-ын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтад уялдсан байх тул одоогийн нөхцөлд хамгийн зардал багатай хувилбар болно.

2.1.2 Засгийн газарт үүсэх зардлын тооцоо

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистик мэдээллийг тооцсон болно.

2.1.2.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 16/51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгээр тогтоосон ЗГ-т холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэхэд тухайн байгууллагад шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлъё.

Чиг үүрэг 1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах

Хуулийн төслийн 16/51 дүгээр зүйлийн 51.6-д “Энэ хуулийн 49.1, 49.2-т заасан этгээд хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.” гэж заасан.

Хүснэгт 17. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
ЗГХЭГ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан хүлээн авах	10	30	300
	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын	10	30	300

	үнэлгээний тайланг цахим хэлбэрт оруулах			
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах	20	30	600
Нийт				1200

Хүснэгт 18. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
ЗГХЭГ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан хүлээн авах	300	96000	0.003
	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг цахим хэлбэрт оруулах	300	96000	0.003
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах	600	96000	0.006
Нийт				0.012

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ЭЗМНС-д байршуулах үүргийг хэрэгжүүлэхэд нийт 30500 минут зарцуулах ба шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ **0.012** байна.

Чиг үүрэг 2. Засгийн газрын санаачилсан хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах

Хууль тогтоомжийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг нэгтгэн ЭЗМНС-д байршуулах чиг үүргийг ЗГХЭГ-ын холбогдох нэгж тогтмол буюу тасралтгүй гүйцэтгэх үүрэгтэй ба тохиолдлын тоог тогтоохдоо ЭЗМНС www.legalinfo.mn болон www.d.parliament.mn 2024.01.01-2024.12.15-ны өдрийн хооронд санал авахаар байршуулсан төслийн тоог үндэслэж дундаж тоог тогтоон баримжаа болгов.

Хүснэгт 19. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
ЗГХЭГ	ЭЗМНС-д эрх бүхий этгээд нэвтрэх	5	30	150

Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт саналын товъёгийг байршуулах	20	30	600
Нийт			750

Хүснэгт 20. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
ЗГХЭГ	ЭЗМНС-д эрх бүхий этгээд нэвтрэх	150	96000	0.001
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах	600	96000	0.006
Нийт				0.007

2.1.2.2 Гарах зардлыг урьдчилан тооцох

ЗГХЭГ-ын холбогдох албан хаагчийн цалинг Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, МУИХ-ын 2019 оны 18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай”-г тус тус үндэслэж тогтоолоо.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг болон хуулийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах мэргэжилтний албан тушаалын цалинг АА-8 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ нь 2,048,000 төгрөг байхаар тооцов.⁵ Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,530,480 төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 30,365,760 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 379,572 төгрөг буюу жилд 4,554,864 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар 34,920,624 төгрөг байна.

Уг зардлыг дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 20. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
ЗГХЭГ	Чиг үүрэг 1= 0.12	34,920,624	4,190,474

⁵ Мөн тэнд.



	Чиг үүрэг 2=0.007	34,920,624	244,444
--	-------------------	------------	---------

2.1.2.3 Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 21. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434

Хүснэгт 22. Төрийн байгууллагад нэмэгдэж буй материаллаг зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн материаллаг зардал	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
ЗГХЭГ	Чиг үүрэг 1= 0.12	5,395,434	647,452
	Чиг үүрэг 2=0.007	5,395,434	37,768

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 23. Нийт зардал



Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)
ЗГХЭГ	0.127	4,434,918	685,220

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд ЗГХЭГ-т холбогдох хүний нөөцийн цалингийн зардалд нийт **4,434,918** төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд **685,220** төгрөг, нийт **5,120,138** /Таван сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин найм/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.1.2.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Аргачлалын дагуу, хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах төсвийн зардлыг бууруулах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар бий эсэхийг шалгав. Үүнд:

Тохиолдлын тоог багасгах боломж бий эсэх

Хуулийн төслийн 16/51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгээр тогтоосон ЗГХЭГ-ын хэрэгжүүлэх үүрэг тасралтгүй үргэлжлэх, тогтмол шинжтэй байх тул тохиолдлын тоог бууруулах боломжгүй байна.

Өөр хувилбар бий эсэх

Өнөөгийн байдлаар ЗГХЭГ ЭЗМНС-д Засгийн газрын тогтоол оруулах ажлыг хариуцан гүйцэтгэж байна. Тус байгууллагад ЭЗМНС-д эрх зүйн акт оруулах эрх бүхий мэргэжилтэн ажиллаж байгаа тул төслийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэхгүй гэж үзлээ. Ажлын ачааллыг харгалзан уг ажлыг гүйцэтгэх албан хаагчийн тоог нэмэгдүүлэх боломжтой ч үүнтэй холбоотой зардал их биш юм.

2.1.3 Хууль зүйн үндэсний хүрээлэнд үүсэх зардлын тооцоо


Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа болон жилд гүйцэтгэх давтамжийн тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистик мэдээлэлд үндэслэн тооцсон болно.

2.1.3.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслийн 15/45 дугаар зүйлийн 45.5, 16/51 дүгээр зүйлийн 51.6, 5/38 дугаар зүйлийн 38.738.7 дахь хэсгээр ХЗҮХ-ийн ЭЗМНС-д холбогдох дараах чиг үүргийг тогтоосон байна.

Чиг үүрэг 1. ЭЗМНС-д хөгжүүлэлт хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохируулах

ХБИЭХТХ-д заасны дагуу ЭЗМНС-д байршсан хууль тогтоомжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан бичвэрийн үсгийн хэмжээг өөрчлөх ажлыг хийсэн ба бичвэрийг дуу авиа руу хөрвүүлэх ажлыг туршаад байна. ХБИЭХТХ-ийн зохицуулалт болон хуулийн төслийн үзэл баримтлалд олон нийтийн оролцоог хангах зарчмыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомж, эрх зүйн актуудаас гадна хуулийн хувийн хэргийн бүрдлийг дуу авиад шилжүүлэх шаардлагатай ба ЭЗМНС нь байнгын, тасралтгүй үйл



ажиллагаатай тул тус системд зориулан бичвэрийг дуу, авиад хөрвүүлэх систем хөгжүүлэлтийн ажил хийгдэх хэрэгцээ тулгамдаж байна.

Одоогийн байдлаар бүтэн хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ЭЗМНС-д байршсан хууль тогтоомж, эрх зүйн актыг doc өргөтгөлөөр татаж дараах программууд дээр Чимэгэ Сонур хоолойг /Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үнэгүй ашиглах боломжтой/ ашиглан бичвэрийг дуу авиа руу хөрвүүлж мэдээлэл авч байна. Үүнд:

1. NVDA /Windows/
2. TALKBACK /Android/
3. VOICE OVER /IOS/

Дэлхийн Цахим Сүлжээний Консорциум (W3C)-ийн Вэб Хүртээмжийн Санаачилга (WAI)-аас боловсруулсан Дэлхийн вэб контентын хүртээмжийн удирдамж (WCAG) нь бүх хэрэглэгчдэд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст вэбсайтыг хүртээмжтэй болгоход чиглэсэн олон улсын стандарт юм. Уг стандартын дагуу манай улсад вэб хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгох зөвлөмж гаргах зорилгоор Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоотой хамтарсан үнэлгээний баг 3-5 сая төгрөгөөр үнэлгээ хийдэг байна.

ЭЗМНС-д тохирох системийн сайжруулалтыг хийхийн тулд мэргэжлийн багийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэж, дүн шинжилгээний санал зөвлөмжөөс хамаарч ЭЗМНС-ийн хөгжүүлэлтийн зардлын тооцоо гарах бололцоотой байна.

Мөн ЭЗМНС-д байршсан бүх хууль тогтоомж, эрх зүйн актууд текст хэлбэрээр тул дээр дурдсан NVDA /Windows/, TALKBACK /Android/, VOICE OVER /IOS/ программуудыг холбох боломжтой.

Чиг үүрэг 2. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг байршуулах боломжтой хэсгийг ЭЗМНС-д нэмэх

ЭЗМНС-д хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг байршуулахаас гадна хуулийн хувийн хэргийн бүрдүүлбэрт хамаарах баримт бичгүүдийг нэгтгэн байршуулах боломжтой. Ингэснээр иргэд, олон нийт хуулийн хувийн хэрэгтэй цахимаар танилцах боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой ба хуулийн төслөөр УИХТГ-т “Хуулийн хувийн хэрэгтэй иргэд танилцах боломжийг бүрдүүлэх” гэсэн үүргийг хэрэгжүүлэх юм. Энэ хүрээнд ХТТХ-ийн 40.1.1-40.1.10-т заасан баримт бичгүүдийг байршуулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Чиг үүрэг 3. Хуулийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг байршуулах боломжтой хэсгийг ЭЗМНС-д нэмэх

Хуулийн төсөлд санал авах буюу саналыг тусгасан, тусгаагүй талаар саналын товъёгийг эргэж танилцуулах цэсийг ЭЗМНС-д нэмж хөгжүүлсэн бөгөөд техникийн хувьд бэлтгэл бүрэн хангагдсан тул үүнд нэмэлт зардал үүсэхгүй.

ЭЗМНС-Д хуулийн хувийн хэрэг байршуулахтай холбогдон гарах зардлыг тооцохдоо Аргачлалын “4.4.3.2.үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил, үйлчилгээг тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамааруулна. Тухайлбал, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэдэн жилээр үргэжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцно” гэж заасныг үндэслэн тохиолдлын тоог хүний нөөцийн хэрэгцээнд үндэслэн тооцов.

Хүснэгт 24. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
ХЗҮХ	ЭЗМНС-д хөгжүүлэлт хийх	96000	2	192000
Нийт				192000

Хүснэгт 25. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
ХЗҮХ	ЭЗМНС-д хөгжүүлэлт хийх	192000	96000	2
Нийт				2

ЭЗМНС-д хуулийн төсөлд үүргийг хэрэгжүүлэхэд нийт 96000 минут зарцуулах ба шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ 2 байна.

2.1.3.2 Гарах зардлыг урьдчилан тооцох

Системийн хөгжүүлэлт хийх ажил нь мэдээлэл технологийн мэргэжилтний гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах тул холбогдох албан хаагчийн цалинг Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, МУЗГ-ын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”-г тус тус үндэслэж тогтоолоо.

ЭЗМНС-д хөгжүүлэлт хийх мэдээлэл, технологийн мэргэжилтний албан тушаалын цалинг ТҮ-8 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ нь 1,337,000 төгрөг байхаар тооцов.⁶ Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,133,250 төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 25,599,000 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 319,987 төгрөг буюу жилд 3,839,844 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар 29,438, 844 төгрөг байна.

Уг зардлыг дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 26. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
------	----------------------------------	--	----------------------------------

⁶ Мөн тэнд.



ХЗҮХ	2	29,438, 844	58,877,688
------	---	-------------	-------------------

2.1.3.3 Үр дүнг тооцох

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 27. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434

Хүснэгт 28. Төрийн байгууллагын нэмэгдэж буй материаллаг зардал


Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн материаллаг зардал	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
ХЗҮХ	2	5,395,434	10,790,868

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 29. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)
ХЗҮХ	2	58,877,688	10,790,868

ЭЗМНС-г хөгжүүлэх ажилд ХЗҮХ-д холбогдох хүний нөөцийн цалингийн зардалд нийт 58,877,688 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 10,790,868 төгрөг, нийт **69,668,556** /Жаран есөн сая зургаан зуун жаран найман мянга таван зуун тавин зургаа/ төгрөгийн зардал үүсэхээр байна.



Дэлхийн вэб контентын хүртээмжийн удирдамж (WCAG) стандартын дагуу хөндлөнгийн байгууллагаас ЭЗМНС-ийн хуудсанд үнэлгээ хийлгэх зардлыг тус байгууллагын үнийн саналд тулгуурлан 5,000,000 төгрөгийн зардал үүсэхээр тооцов.

2.1.3.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах төсвийн зардлыг бууруулах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар бий эсэхийг шалгана. Үүнд:

Тохиолдлын тоог багасгах боломж бий эсэх

Судалгааны энэхүү хэсэгт хуулийн төслөөр ХЗҮХ-д үүрэг үүсгэсэн зохицуулалтуудыг сонгон авч үнэллээ. Тус санд хуулийн хувийн хэрэг байршуулахаар нэмэлт хөгжүүлэлт, шинэчлэлт хийх ажил нь тасралтгүй үргэлжлэх, тогтмол шинжтэй ажил байх тул тохиолдлын тоог 1 гэж үзсэн ба үүнээс бууруулах боломжгүй юм. Ажлын ачааллаас хамаарч хүний тоог нэмж, хүний нөөцийн зардал дагаж өсөх магадлалтайг дурдах нь зүйтэй.

Өөр хувилбар бий эсэх

Хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог хангах болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд ЭЗМНС-д дээр дурдсан хөгжүүлэлтийн ажлыг хийх нь төслийн үзэл баримтлалд бүрэн нийцнэ. Системийн хөгжүүлэлт хийх ажлыг Аргачлалын дагуу ХЗҮХ-ийн холбогдох мэргэжилтний цалингаар тогтоож, зардлыг тооцсон тул зах зээлийн үнэлгээнээс харьцангуй бага дүнтэй зардал гарсныг анхаарвал зохино. Өөрөөр хэлбэл “системийн хөгжүүлэлт” хийх чиглэлээр мэргэшсэн, мэргэжилтнүүдийн дундаж цалин нь зах зээл дээр илүү өндөр үнэлгээтэй байгааг анхаарах нь зүйтэй.

2.1.4 Ерөнхийлөгчийн Тамгын газарт үүсэх зардлын тооцоо

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 5/38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгээр Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах үүрэг үүсгэжээ.


МУИХТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно.”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 17.1-д “Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгчийн Тамгын газар мөн.” гэж тус тус заасны дагуу хуулийн төслийн уг чиг үүргийг Ерөнхийлөгчийн Тамгын газар гүйцэтгэж байна

2.1.4.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Чиг үүрэг 1. Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг ЭЗМНС-д байршуулах

Хууль тогтоомжийн төсөлд ирүүлсэн саналын товъёгийг нэгтгэн ЭЗМНС-д байршуулах чиг үүргийг ЕТГ-ын холбогдох нэгж тогтмол буюу тасралтгүй гүйцэтгэх үүрэгтэй ба тохиолдлын тоог тогтоохдоо 2024.01.01-2024.12.15-ны өдрийн хооронд <https://president.mn/> -д санал авахаар байршуулсан төслийн тоог үндэслэж дундаж тоог тогтоон баримжаа болгов.

Хүснэгт 30. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ



Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
ЕТГ	ЭЗМНС-д эрх бүхий этгээд нэвтрэх	5	5	25
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт саналын товъёгийг байршуулах	20	5	100
Нийт				125

Хүснэгт 31. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
ЕТГ	ЭЗМНС-д эрх бүхий этгээд нэвтрэх	25	96000	0.0002
	Эрх бүхий этгээд ЭЗМНС-д нэвтэрч тохирох хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах	125	96000	0.001
Нийт				0.001

2.1.4.2 Гарах зардлыг урьдчилан тооцох

ЕТГ-с уг чиг үүргийг гүйцэтгэхэд улсын төсөвт ачаалал үүсгэхгүй буюу чиг үүргийг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа харьцангуй бага тул хүний нөөцийн нэмэлт зардал 0.001-ээр нэмэгдэх буюу цалингийн зардал гарахгүй байна. Энэ нь тус байгууллага одоогийн бүтэц, орон тоонд тулгуурлан чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн боломжтойг харуулж байна.

III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Судалгааны энэхүү хэсэгт, хуулийн төсөлд хуулийн этгээдэд тодорхой төрлийн үүрэг гүйцэтгэхийг даалгасан буюу шаардсан бол үүний дагуу төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргах юм.

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтооно. “Гүйцэтгэх үүрэг” гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;

- 
2. Нэг бүрийн зардлыг тооцох;
 3. Тоон үзүүлэлтийг тооцох;
 4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
 5. Хялбарчлах боломжийг шалгах;
 6. Нэмэлт зардлыг тооцох.

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд дунджаар хэр их цаг хугацаа зарцуулахыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоо хийдэг.

ХТТХНӨТХ-ийн төсөлд хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хамааралтай шинээр үүрэг үүсгэсэн эсхүл одоо гүйцэтгэж байгаа үүргийг өргөжүүлсэн шинжтэй зохицуулалт тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл шууд болон шууд бусаар хуулийн этгээдэд үүрэг бий болгосон заалт байхгүй буюу зохицуулалтууд нь бүхэлдээ төрийн байгууллагын үүрэгт хамааралтай байна. Иймд хуулийн төсөл нь аж ахуйн нэгж байгууллагад зардал үүсгэхгүй учир хуулийн этгээдийн зардал тооцоолох үе шатын дагуу шалгах шаардлагагүй юм.



IV. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Судалгааны энэхүү хэсэгт хуулийн төслөөр иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг шалгаж, тус үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацаа /ачаалал/ гарах зардлыг тооцно. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжид заасны дагуу нэг бүрчлэн тогтооно. Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах иргэн хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараах үе шатыг баримтална. Үүнд:

1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах.

Иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Хуулийн төсөлд иргэнд үүрэг үүсгэсэн зохицуулалт тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл шууд болон шууд бусаар үүрэг бий болгосон заалт байхгүй буюу зохицуулалтууд нь бүхэлдээ төрийн байгууллагын үүрэгт хамааралтай байна.

Иймд хуулийн төсөл нь иргэнд зардал үүсгэхгүй тул иргэнд үүсэх зардал тооцоолох үе шатын дагуу шалгах шаардлагагүй юм.

V. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тодорхойлох, зардал бууруулж, ачааллыг багасгах хувилбарын талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ. Ингэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан тооцоолов.

ХТТХНӨТХ-ийн төсөл нь хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог хангах болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах гэсэн гурван хүрээг хамарсан 6 зүйлтэй. Хуулийн төсөлд Аргачлалын 1.4.2-т заасны дагуу ХТТХНӨТХ-ийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, тэдгээр субъектэд ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарын талаар судалж, дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тухайд

Хуулийн төслийн зохицуулалт нь УИХТГ, ЗГХЭГ, ХЗҮХ-д үүрэг үүсгэсэн ба үүнтэй холбогдох эдгээр байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр зардлын тооцоог хийж, зардлыг бууруулах боломжит хувилбарын талаар санал боловсруулж судалгааны тайланд тусгасан. Тухайлбал уг хуулийн төсөл батлагдсанаар хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагад дараах хэмжээний зардал үүсэхээр байна. Үүнд:

УИХТГ-д холбогдох хүний нөөцийн цалингийн зардалд хүний нөөцийн цалингийн зардалд нийт 30,823,254 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 3,237,260 төгрөг, нийт **34,060,514** /Гучин дөрвөн сая жаран мянга таван зуун арван дөрөв/ төгрөгийн зардал;

ЗГХЭГ-т холбогдох хүний нөөцийн цалингийн зардалд нийт **4,434,918** төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд **685,220** төгрөг, нийт **5,120,138** /Таван сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин найм/ төгрөгийн зардал;

ЭЗМНС-ийн хөгжүүлэх ажилд **ХЗҮХ-д** холбогдох хүний нөөцийн цалингийн зардалд нийт 58,877,688 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 10,790,868 төгрөг, нийт 69,668,556 төгрөгийн зардал болон вэб хуудсын үнэлгээний зардалд **5,000,000** төгрөг нийт **74,668,556** /Далан дөрвөн сая зургаан зуун жаран найман мянга таван зуун тавин зургаа/ тус тус үүснэ.

ЕТГ-т хуулийн төслийн өргөжүүлсэн чиг үүргийг гүйцэтгэхэд нэмэлтээр хүний нөөцийн зардал үүсгэхгүй буюу улсын төсөвт ачаалал үзүүлэхгүй юм.


ХТТХНӨТХ-ийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад **нийт 113,849,208** төгрөгийн зардал үүсэх төлөвтэй байна.

Хоёр. Хуулийн этгээд болон иргэнд үүсэх зардлын тухайд

Хуулийн төсөлд иргэн болон хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар үүрэг бий болгосон заалт тусгагдаагүй буюу зохицуулалтууд нь бүхэлдээ төрийн байгууллагын үүрэгт хамааралтай байх тул Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн болон хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзсэн.

Зардал-үр өгөөжийн харьцаа

ХТТХНӨТХ-ийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс тодорхой зардал шаардах боловч эдийн засагт дарамт үүсгэхгүй ба хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад харьцангуй бага зардлаар өндөр үр өгөөж хүртэх буюу нийгэмд эерэг нөлөөлөл бий болоход зарцуулагдах зардал гэж үзсэн. Иймд тус хуулийн төсөл батлагдсанаар холбогдон гарах зардлыг байж болохуйц хэмжээ гэж дүгнэв.



Түүнчлэн оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар төрд үүсэх ачааллыг багасгаж, зардлыг бууруулах боломжтой гэж үзэж байна. Тухайлбал, дараах 2 асуудлыг шийдвэрлэх нь зардал хэмнэхэд ихээхэн ач холбогдолтой. Үүнд:

- a. УИХТГ-ын Парламентын номын санг нийтэд нээлттэй болгох замаар хуулийн хувийн хэрэгтэй танилцах нөхцөлийг бүрдүүлэх;
- b. Хуулийн хувийн хэрэгтэй цахимаар танилцах боломжийг бүрдүүлж ЭЗМНС-д байршуулах.



ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2024.
3. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993.
4. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.
5. Засгийн газрын 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, 2016.